


ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ УУСМАЛТАЙ ВАННД ХЭРХЭН ОРУУЛАХ ТУХАЙ


Халдваргүйжүүлэх уусмалтай ванн нь арьсан дээрх нянгийн хэмжээг багасгаж экземийн тууралт халдварт өртөхөөс сэргийлдэг. Халдваргүйжүүлэх уусмалтай ваннд экземтэй хүүхэд болон насанд хүрэгчид орох боломжтой.

Танд дараах зүйлс хэрэгтэй. Үүнд:

- Ванн
- Ус – халуун нь 30 градусаас ихгүй
- 10 литрийн ахуйн хувин
- Ахуйн хэрэглээний үнэргүй White King халдваргүйжүүлэх уусмал – 10 литр усанд 12мл-ийг хийх
- Ванны тос – хэрэглэхийг зөвлөсөн бол нэг удаагийн ваннд 1-2 аяга дүүрэн хийх
- Усан сангийн эсвэл хоолны давс – хэрэглэхийг зөвлөсөн бол 10 литр усанд 1/3 аяга




Эхлэхээсээ өмнө гараа угааж, хатаана.




Ваннаа 10 литрийн хувингаа ашиглан усаар дүүргэх ба ингэснээр хэр их хэмжээний ус нэмж байгаагаа хэмжих боломжтой болно.


ЗӨВЛӨМЖ
Ванны усны түвшний хэмжээг арилдаггүй үзгээр эсвэл сайн наалддаг скочоор тэмдэглэж авах нь зүйтэй. Ингэснээр усанд оруулах бүртээ хэмжих шаардлагагүй болно.



Ванн доторх усны 10 литр тутамд 12мл халдваргүйжүүлэх уусмал нэмж хийнэ (гэр бүлийн ванн-д тал хүртэл нь усаар дүүргээд аяганы 1/4 хэмжээгээр халдваргүйжүүлэх уусмал хийнэ). Хэрэглэхийг зөвлөсөн тохиолдолд давс болон ванны тос нэмж болно.



Ванн доторх усны 10 литр тутамд 1/3 аяга давс нэмж хийнэ.




Хүүхдийг ваннд угаахдаа нүүр болон толгойг нь норгох ба нүдэнд нь ус оруулахаас болгоомжлоорой.




Ванны тосноос 1-2 бүтэн аяга нэмж хийнэ.



Хэрвээ таны хүүхдийн арьсанд тууралт болон хайрсжилт үүссэн бол хайрсжсан хэсгийг нь хөнгөхөн цэвэрлэхийг хичээгээрэй.



Хүүхдийн арьсыг цэвэрлэж дуусаад халдваргүйжүүлэх уусмалтай ваннаас нь гаргана – ваннаас гарсны дараа хүүхдээ усаар зайлж болохгүй. Хүүхдийн биеийг алчуураар хөнгөхөн дарах маягаар хатаана.



Стероид тосон түрхлэг болон чийгшүүлэгчийг эмч эсвэл сувилагчийн зөвлөсний дагуу түрхэнэ.